



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ЗАЯАБАЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.13 № 05/6229
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Нийслэлийн татварын газрын Төсвийн орлого, удирдлагын хэлтсийн татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Ёндонгийн Энх-Оюун, Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Төмөр-Очирын Хуланзаяа, Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Жадамбаагийн Удвалцэцэг, Баянгол дүүргийн татварын хэлтсийн Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Цэвээннамжилын Амгалан, Хэнтий аймгийн татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Баянмөнх сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Энхбатын Өсөхжаргал, Дундговь аймгийн татварын хэлтсийн Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн Цагаандэлгэр сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Хоролсүрэнгийн Оюунбилэг, Хөвсгөл аймгийн татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Бүдийн Өлзийтогтох, Захиргаа, хуулийн тасгийн хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Намдагийн Биндэръяа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142303006193